



“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2018. 7. 23

№2018/11

Улаанбаатар хот

“Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын бүрэлдэхүүн ба нарийн бичгийн даргыг батлах тухай”

“Компанийн тухай” хуулийн 81, 82 дугаар зүйл, “Улаанбаатар БҮК” ХК-ийн Дүрмийн 7.38 болон 7.44 дэх заалт, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 8.1 болон 9.1 дэх заалт, “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 11-р сарын 11-ны өдрийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

1.1. Аудитын хороо

❖ Дарга-Д.Дэлэг

Гишүүд-С.Батбилэг
Л.Мөнхсайхан

1.2. Цалин урамшуулалын хороо

❖ Дарга-С.Батбилэг

Гишүүд-Х.Ю.Хамхоев
Г.Цогнэмэх

1.3. Нэр дэвшүүлэх хороо

❖ Дарга-С.Б.Громов

Гишүүд-Г.Цогнэмэх
Д.Дэлэг

2. “Улаанбаатар БҮК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын санал болгосноор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Д.Байгальмааг томилсугай.

3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Байгальмаа/-д болон Хороодын дарга Д.Дэлэг, С.Батбилэг, С.Б.Громов нарт:

Монгол улсын “Компанийн тухай” хууль, “Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрэм, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” болон бусад холбогдох хууль, дүрэм журмыг үүрэгт ажилдаа мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

4. Энэхүү Тогтоол батлагдсантай холбогдуулан “ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай” 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн № 2017/13 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

.....ДНЯМХҮҮ





**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018.7.23

№2018/12

Улаанбаатар хот

**Г “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 80 дугаар зүйлийн 80.6 дахь заалт
“Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.51.13 дахь заалт, ТУЗ-ийн ээлжит
хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг “хангалттай” гэж баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.НЯМХҮҮ





“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2018.7.23

№2018/10

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг батлах тухай

“Компанийн тухай” хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, “Улаанбаатар БҮК” ХК-ийн Дүрмийн 7.27 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын №2018/03 тоот Тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100%-ийн саналаар Даваа овогтой Нямхүүг ТУЗ-ийн даргаар томилж баталсугай.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааг “Компанийн тухай хууль”, “Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрэмд нийцүүлэн оновчтой зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн дарга/Д.Нямхүү/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

С.Б.ГРОМОВ.....

Х.Ю.ХАМХОЕВ.....

Д.НЯМХҮҮ.....

Д.МӨНХӨӨ.....

Б.ЖАМБАЛ.....

Л.МӨНХСАЙХАН.....

Д.ДЭЛЭГ.....

С.БАТБИЛЭГ.....

Г.ЦОГНЭМЭХ.....